

ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

COOPERATION OF LAW ENFORCEMENT ORGANIZATIONS TO DEFENSE BORDER SECURITY

**Б.БАТБАЯР**

ХХЕГ-ийн харьяа Хилийн 0257 дугаар ангийн захирагч, докторант,
хурандаа

BATBAYAR B.

Ph.D. Candidate, Colonel, Commander, Border Unit 0257

Товч утга: Илтгэлийн агуулга нь хилийн аюулгүй байдлын тухай ойлголт, төрөөс авч хэрэгжүүлж буй бодлого, монгол улсын хилийн аюулгүй байдалд учирч болзошгүй аюул, үүнээс урьдчилан сэргийлэхийн тулд хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагааг хэрхэн зохион байгуулбал үр өгөөжтэй болох талаар өөрийн саналыг тусгасан болно.

Abstract: The article is to emphasize the understanding of the border security and the government policies. It is to determine my point on efficiency of law enforcement organization's cooperation to safeguard and defense Mongolian border security.

Түлхүүр үгс: Хилийн аюулгүй байдал, оршин тогтнохын аюулгүй байдал, үндэсний аюулгүй байдал, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал.

Key words: Border Security, Inviolability of Existence, National Security, The National Security Concept.

Монгол Улсын хоймор болсон хөвсгөлийн цэнхэр хязгаар, улсын хилийн 1000 гаран км хэсгийг хамгаалж халдашгүй дархан байдлыг хангахын төлөө хүчин зүтгэж байгаа хилчдийнхээ нэрийн өмнөөс энэхүү олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцохоор ирсэн Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргье.

Даяаршиж байгаа өнөө үед хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчил зохион байгуулалтын хэлбэрт шилжин олон улсын чанартай болж байгаа нь хилийн аюулгүй байдалд шууд болон дам нөлөөж байгаа билээ. Энэ нь дан ганц хил хамгаалах байгууллагын авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээгээр хангагдахгүй байгааг харуулж байна. Тиймээс хилийн аюулгүй байдлыг хангахад хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулж, боловсронгуй болгон бэхжүүлэх асуудал тулгамдаж байна.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангахад Хил хамгаалах байгууллага, хилчдийн эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг, ач холбогдол өсөн нэмэгдсээр байна. 2001 онд Улсын Их хурлаар батлагдсан Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн хоёрдугаар бүлгийн 6 дугаар зүйлд “Үндэсний аюулгүй байдлын тогтолцоо нь Монгол Улсын Их хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, түүний тэргүүлсэн үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй төрийн байгууллага, орон нутгийн өөрөө

удирдах байгууллага болон холбогдох албан тушаалтнуудаас бүрдэнэ"; гэж заасан билээ. "Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого"-д "Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх, байгууллага, иргэдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хилийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах асуудлыг Засгийн газар хариуцана" гэж заажээ

Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого нь улс орны нийтлэг бодлого, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын бүрэлдэхүүн хэсэг билээ. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (II бүлэг)-д төрийн язгуур ашиг сонирхлын 6 орчин бүртгэгджээ. Үүнд:

1. Оршин тогтнохуйн,
2. Эдийн засгийн,
3. Дотоодын,
4. Хүний,
5. Хүрээлэн байгаа орчны,

6. Мэдээллийн ашиг сонирхлууд юм. Тэгэхээр албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн, улс орны хилийн аюулгүй байдлыг хангах зорилго, зорилт, зарчмууд, үндсэн чиглэл, хэрэгжүүлэх механизмуудын талаарх ойлголтууд энэ бодлогын үндэс болдог. Уг баримт бичиг бол хилийн аюулгүй байдлыг хилийн орчинд хангах чухал ач холбогдолтой юм. Хилийн талаар баримтлах бодлогыг "Улсын хилийн хамгаалалтын найдвартай байдлыг хангах, хилийн асуудлуудаар тулгамдаж буй шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх, улсын хил, хилийн орон зайд төр, нийгэм, иргэдийн язгуур эрх ашгийг хамгаалахад чиглэсэн хилийн орчны харилцааг зохицуулах төрийн захиргааны байгууллага, бусад субъектүүдийн үйл ажиллагаа" гэж тодорхойлж болох юм. Энэ бүхэн Монгол Улсын хил хамгаалах байгууллагын төрийн захиргааны байгууллага болон гүйцэтгэх үүргийн онцлогоор Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын тогтолцоонд багтаж аюулгүй байдлыг хангах хэрэгт оролцон тодорхой үүрэг, хариуцлага хүлээх эрх зүйн үндсийг бүрдүүлж байна.

Төрийн захиргааны нэгэн субъект хил хамгаалах байгууллага нь "Монгол Улсын хилийн баталгаажилт, халдашгүй дархан байдлыг хангах, улсын хилийг хамгаалахдаа үндэсний аюулгүй байдлыг хангах тодорхой үүрэг, зорилтыг хэрэгжүүлж байна" гэж үндэсний аюулгүй байдлын тухай хуульд тодорхой заасан байна. Энэ хуульд "Үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ" гэж заажээ. Үүнээс Монгол Улсын хил хамгаалах байгууллага, хилийн цэргээс хилийн аюулгүй байдал гэж юу болохыг тодорхойлох шаардлага гарч ирж байгаа юм. Эдгээр тодорхойлолтоос үзэхэд хилийн аюулгүй байдал бол үндэсний аюулгүй байдлын "үндсэн бүрэлдэхүүн хэсэг" буюу "бие даасан төрөл" гэж үзэж болох юм. Тэгвэл хилийн аюулгүй байдал гэдэг нь "улсын хил, хил орчмын нутаг дэвсгэр, (хилийн орон зай)-д үндэсний аюулгүй байдал найдвартай хангагдах гадаад, дотоод нөхцөл баталгаатай хангагдах явдал" гэж үзэж болно.

Аюулгүй байдлаа сахих зорилго нь нийгэмд зэвсэгт хүчин, хил хамгаалах алба, цагдаа, хамгаалалтын болон онцгой байдлын албаны зэрэг хүчний байгууллагуудыг буй болгоход хүрч, улмаар дэлхий ертөнцийн нийт хүн амын аюулгүй байдлыг хангах үүрэгтэй НҮБ-ыг байгуулахад хүргэсэн байна. Аюулгүй байдлын тогтолцоо "хэврэг" байх нь улс орон задрах, үндэстэн ястан устах, цус

урсгасан зөрчил мөргөлдөөн үүсэх, материаллаг үнэт зүйлс эвдрэн сүйдэх зэрэг гай гамшигт хүргэнэ. Улс үндэстний аюулгүй байдал алдагдах явдал юун түрүүнд улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрээс эхлэх магадлал өндөр байдаг болохоор хилийн аюулгүй байдлыг хангах асуудлыг тэргүүн ээлжинд шийдвэрлэх нь чухал. Хөвсгөл аймгийн хэмжээнд хилийн аюулгүй байдлыг хангахын тулд үндэсний аюулгүй байдлыг хамгаалах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд (Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газар, хууль зүйн хэлтэс, цэргийн штаб, аймгийн тагнуулын хэлтэс, онцгой байдлын хэлтэс, цагдаагийн газар Иргэний харьяат шилжилт хөдөлгөөний ерөнхий газар, Тахарын 8 дугаар тойрог, Зэвсэгт хүчний 321 дугаар салбар)-ын хамтын ажиллагааг улам бүр тодорхой, идэвхтэй болгох шаардлагатай байна.

Монгол Улсын хил хамгаалах байгууллага, хилчдийн үндсэн үүрэг нь улсын хилийн баталгаажилт, хамгаалалтын найдвартай байдлыг ямарч нөхцөлд хангах явдал юм. 2010 онд батлагдсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын “Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг, хангах арга зам” гэсэн гуравдугаар бүлэгт: “Оршин тогтнохын аюулгүй байдлын үндэс нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хил хязгаарын халдашгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал” юм гэжээ. Тиймээс улсын хилийн аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг оршин тогтнохуйн аюулгүй байдлын нэг хэсэг болох нь тодорхой юм. Хилийн аюулгүй байдлын тухай ерөнхий ойлголт, түүнд хийсэн дүгнэлт болон дээрх эрх зүйн актуудыг үндэслэн хилийн аюулгүй байдлыг дараах байдлаар томъёолж байна. Үүнд:

1. Монгол Улсын төр, нийгэм, иргэний язгуур ашиг сонирхол хилийн орчинд хангагдсан байдал буюу энэ орчинд төр, нийгэм, иргэнд ямар нэгэн аюул занал учрахгүй, хилийн боомтоор улсын хил нэвтрэх бүх бололцоог хангасан, хилийн болон хил орчмын дэглэм сахиулан, зөрчлийг цаг алдалгүй таслан зогсоох, гаргахгүй байх.

2. Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг хангах механизм, түүний үндсэн чиглэл, зарчим, үүрэг, зорилгын талаар албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн үзэл баримтлалын тогтолцоотой байх.

Хилийн аюулгүй байдал нь Монгол Улсын төрийн, орон нутгийн засаг захиргааны болон төрийн бус байгууллагууд хилийн болон хил орчмын нутаг дэвсгэрт өөрсдийн эрх мэдлийн хүрээнд улс төр, эрх зүйн, дипломатын, батлан хамгаалах, цэргийн, хилийн, тагнуулын, оператив-эрлийн, гаалийн, экологийн, хүн-мал эмнэлгийн ба бусад арга хэмжээг нэгдмэл бодлоготой, харилцан уялдаатай явуулах зэрэг үйл ажиллагаагаар хангагдана. Гэвч хилийн шугамын дагуу инженерийн төхөөрөмжлөл, эсрэг талдаа цэрэгжүүлсэн хамгаалалтгүй байгаа, байгалийн баялаг хууль бусаар ашиглах, ашиг хонжоо хайсан орон нутгийн иргэдийн буруу үйл ажиллагаа, хилийн бүс зурваст явагдаж байгаа үйл ажиллагаанууд тэр дундаа уул уурхайн олборлолт зэрэг нь хилийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байгаа гол хүчин зүйлүүд гэж үзэж болох юм. Ингэхээр хилийн аюулгүй байдлыг хангахын тулд холбогдох эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгох, хууль сахиулах байгууллагуудын нэгдмэл ажиллагааг хангах бүх талын арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлага зайлшгүй тулгарч байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг толгойлдог, төрийн тэргүүний хувьд үндэсний аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий байгууллага, хүч хэрэгслүүдийг ерөнхий удирдлагаар хангах, үйл ажиллагаанд хяналт тавих,

дээрх байгууллагуудыг хууль тогтоомжийн дагуу татан буулгах, өөрчлөн зохион байгуулах, үндэсний аюулгүй байдалтай холбогдолтой илгээлт, удирдамж, уриалга гаргах, үндэсний аюулгүй байдлын эрх зүйн актуудын зарим заалтад тодотгол хийх, дотоод, гадаад бодлогын чиглэлийг тодорхойлох зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Монгол Улсын Ерөнхийлөгч хилийн аюулгүй байдалтай холбоотой асуудлаар гүйцэтгэх засаглалын байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, зохион байгуулах асуудлуудыг шийдвэрлэнэ.

Үндэсний аюулгүй байдлын тогтолцоог бүрдүүлж, өдөр тутмын удирдлагаар хангадаг ажлын аппарат нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөл мөн бөгөөд тэр нь үндэсний аюулгүй байдлыг хангах салбарт хэрэгжүүлэх Ерөнхийлөгчийн шийдвэрийн саналын төслийг бэлтгэж, уг шийдвэрийг төрийн захиргааны төв байгууллагууд хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих үүрэгтэй. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл нь хилийн аюулгүй байдлыг хангах зорилтуудаа Засгийн газрын тэргүүний удирдлагын дор байгуулсан "Улсын хилийн комисс"-оор дамжуулан шийдвэрлэж байдаг ОХУ-ын туршлагыг бид хэрэгжүүлэх боломжтой.

Монгол Улсын хил хамгаалах алба нь хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцооны цөм институц бөгөөд хил хамгаалах байгууллагуудыг удирдах төв байгууллага болохынхоо хувьд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хилийн аюулгүй байдалд учирч болзошгүй аюул заналын талаар мэдээлэл цуглуулж боловсруулан Монгол Улсын Ерөнхийлөгчид танилцуулах Монгол Улсын гүйцэтгэх засаглал, тэдгээрийн харьяа орон нутгийн байгууллагуудад хилийн цагийн байдлын талаар мэдээлэх, улсын хилийг манах, хамгаалах үед гүйцэтгэх засаглалын болон орон нутгийн байгууллагуудын хамтын үйл ажиллагааг удирдан уялдуулах шуурхай штабуудыг байгуулах, хүч хэрэгслийг зохицуулах, улс төр, эдийн засаг, цэргийн болон бусад ашиг сонирхлыг хилийн орон зайд дээрх байгууллагуудын хүч хэрэгслийг ашиглан хамгаалах, хамтарсан арга хэмжээнүүдийг (хилийн операци, хилийн эрэл) төлөвлөж хэрэгжүүлэх, улсын хил хамгаалалтын талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлж, улсын хил хамгаалалтыг зохион байгуулах, Монгол Улсын болон олон улсын гэрээнд хилийн асуудлаар хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх, улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулж, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг зохих журмын дагуу нэвтрүүлэх зэрэг хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлнэ.

Орчин үед Монгол Улсын хилийн аюулгүй байдалд учруулж болзошгүй аюулуудыг нэрлэвэл:

- Хил залгаа улсуудын цэргийн бүлэглэлүүдийн тоо нэмэгдэх;
- Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт гадаадын тусгай албадын тагнуул - хорлон сүйтгэх үйл ажиллагааны хүрээ өргөжих;
- Хил залгаа улсуудын хилийн орчимд улс төр, үндэстэн хоорондын, шашны болон бусад сөргөлдөөн, орон нутгийн зэвсэгт мөргөлдөөн зэрэг гадаад, дотоод түгшүүрт байдлын голомтууд үүсэх;
- Гуравдагч орны иргэд Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин олноор цагаачлах, тэдний зарим нь хилийн ойролцоо үлдэхийг оролдох;
- Гадаадын иргэд, тэр дундаа хууль бус цагаачдыг улс орны эдийн засгийн орон зайд нэвтрүүлэх;
- Хил орчмын улсуудтай найрамдалт харилцаа холбоо сулрах;
- Улс орон гадаад эдийн засгийн байр сууриа алдах, хил залгаа бүс нутагт гадаадын зах зээлд гарах нь багасах;

• Гэмт хэргийн бүлэглэлийн хууль бус наймаа болон хууль бус үйлдэл, ялангуяа улсын хилийн зарим хэсэгт олон улсын хар тамхины наймаа идэвхжих зэрэг үйл ажиллагаа юм.

Хилийн аюулгүй байдлыг хангах гол зорилго нь хилийн орчинд Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг гадаад, дотоодын аюул, заналаас хамгаалах төр, нийгэм, иргэний аюулгүй байдлыг хангахдаа юуны урьд хилийн талаар байгуулсан олон улсын гэрээ хэлэлцээр, эрх зүйн хэм хэмжээг сахих, зэргэлдээ улстай хамтын ажиллагаагаа хөгжүүлэх бүх талын бололцоо олгоход оршино. Үүнээс үндэслэн хилийн аюулгүй байдлыг хангах үндсэн зорилт бол газар нутгийн бүрэн бүтэн байдал, улсын тусгаар тогтнолыг хангах, улсын хил, хязгаар нутагт сайн хөршийн харилцаа, энх тайвнаар зэрэгцэн оршиход чиглэгдсэн, хилийг зөрчилгүй байлгах болон улсын зарчим, бусад улс хоорондын эрх зүйн хэм хэмжээг сахиулах, улсын хилийн шугамын явалтыг хууль бусаар өөрчлүүлэхгүй байх, хилийн дэглэм, журмыг хувь хүмүүс, хуулийн этгээдүүдээр сахиулах явдал мөн байна. Хилийн аюулгүй байдлыг хангах ажиллагааны гол зорилт нь хилийн аюулгүй байдлын аюул заналыг илрүүлэн гаргах, аюул заналын эсрэг тэмцэл явуулах юм. Тиймээс хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг хангахын тулд дараах санал, зөвлөмжийг дэвшүүлж байна. Үүнд:

1. Улс орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн аюулгүй байдлыг хангахад хилийн талаарх олон улсын эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгох;

2. Улсын хил дээр болон хил орчмын нутаг дэвсгэрт цэргийн аюул, хурцадмал байдал, зэвсэгт болон зэвсэггүй мөргөлдөөн гарахаас урьдчилан сэргийлэх талаар улс хоорондын хэлэлцээр байгуулах;

3. Бусад улс орны (хил залгаа) зүгээс өөрийн орны нутаг дэвсгэрт хүчээр шилжин суурьших, эдийн засгийн түрэмгийллийн эсрэг чиглэсэн арга хэмжээг авах;

4. Улсын үндэсний эрх ашгийн үүднээс хилийн орон зайд цэрэг улс төрийн бүлэглэл болон бусад олон улсын зүгээс тусгаарлагдмал байдалд орох аюулыг арилгах;

5. Гэмт хэргийн үйлдлийг (санаатайгаар улсын хил зөрчих, хууль бусаар буу зэвсэг, мансууруулах бодис, эд зүйлс нэвтрүүлэх, хил дамнасан гэмт бүлэг орж ирэх г.м) таслан зогсоох чадвартай байхын тулд улсын хил хамгаалалтад орчин үеийн техник технологийг нэвтрүүлэх;

6. Улсын хил болон хил орчмын нутаг дэвсгэрийг хамгаалах үүрэг бүхий субъектүүдийн нэгдмэл ажиллагааг хангах шаардлагатай байна.

Эх сурвалжийн жагсаалт:

1. Хилийн тухай хууль УБ. 1993 он
2. Үндэсний аюулгүй байдлын тухай хууль. УБ. 2001 х.35
3. Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, үзэл баримтлал
4. Төрөөс хилийн талаар баримтлах бодлого.
5. Бүсчилсэн хил хамгаалалтын хөтөлбөр УБ. 2011 он
6. Хил хамгаалалтын дүрэм I анги
7. Батлан хамгаалах салбарын хууль тогтоомжийн эмхэтгэл. УБ. 1995 х.74
8. “Монгол улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөл” эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл. УБ. 2002 х.37
9. Харичкин И.К.Национальная безопасность//матер.меж.вед. научной-практ.

конф. М:МВИ ФПС России.2001.с.6

10. Правовая основа обеспечения национальной безопасности Российской Федерации:

11. Монография / Ю.И.Авдеев, С.В.Аленкин, В.В.Алешин и др /Подред. А.В.Опалева М.2004.с.15

12. Ш.Арвай. Улсын хилийн тухай дурсамж, үзэл бодол. УБ. 2005 х.185

13. Хил судлал сэтгүүл. УБ. 2009. №03, 04

14. Ч.Дашдэлэг. Хилийн асуудал. УБ. 2008

15. Т.Төртогтох. Улсын хилийн аюулгүй байдал. УБ. 2004. х.75